



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/130

Амардалай

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "м", Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, Аймгийн ИТХ-ын 2015 оны 52 тоот тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутаг Бага газрын чулуу, Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг Халтарын уул, Цагаан толгой орчмын эргүүл, хамгаалалтанд зориулж "Зэт Би Эс Ди" ХХК-д 180.500 төгрөг, "Дэлгэр-Алтанзагас" ХХК-д 271.950 төгрөг нийт 452.450 /Дөрвөн зуун тавин хоёр мянга дөрвөн зуун тавин/ төгрөгийг Байгаль хамгаалах сангийн зардлаас зарцуулсугай.

Хоёр. Холбогдох бичиг баримтыг бүрдүүлж гүйлгээ хийхийг ня-бо /Б.Энхманлай/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ИШ-ЁНДОН